



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 1/78

Батноров сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг гэрчилгээний хугацаа сунгах тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу “Ашдын чуулга” ХХК-ний Дундбүрд 6 дугаар багийн Нөөлөг гудамжны 501 а тоотод байрлах авто замын сургалт, дадлагын талбай зориулалттай 2304012285 нэгж талбарын дугаар бүхий 2500 квадрат метр газрын эзэмших эрхийн гэрчилгээг 30 жилийн хугацаатай сунгасугай.

2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг “Ашдын чуулга” ХХК-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны А/49 тоот захирамжийг хүчингүй болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР